

## **ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 38 дугаар зүйлд заасны дагуу татварын шинэчлэлийг улс орон даяар бүх нийтийг хамарсан өргөн хүрээний хэлэлцүүлгийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлүүлж, татвар төлөгч, эрдэмтэн судлаач, худалдааны танхим зэрэг бүх талын оролцоог хангуулан нээлттэй санал авах ажлаар эхлүүлж, фокус группийн судалгааг хийсэн.

Өнгөрсөн хугацаанд Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар, Эдийн засгийн хөгжлийн зөвлөлтэй хамтран улс орон даяар, давхардсан тоогоор 13,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, 176 мянга гаруй саналыг хүлээн авсан.

Татварын шинэчлэлийн хүрээнд зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгүүд нь улс орон даяар өргөн хүрээг хамарч, салбар бүрийн онцлогт тулгуурлан, олон талын оролцоог ханган зохион байгуулагдсан. Мэргэжлийн холбоод, салбарын татвар төлөгчид, хуульч, сэтгүүлч, томоохон аж ахуйн нэгжүүдийг хамруулсан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан бөгөөд орон нутгийн түвшинд 21 аймгийн татварын газраар дамжуулан иргэд, аж ахуйн нэгжүүдийг өргөнөөр хамруулсан. Тухайлбал:

№	Зохион байгуулагч	Оролцогчид/Сэдэв	Хэлэлцүүлгийн тоо	Оролцогчийн тоо
1	Татварын ерөнхий газар	<ul style="list-style-type: none"><li>• Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт;</li><li>• Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг;</li><li>• Монголын үнэлгээчдийн холбоо;</li><li>• Бусад мэргэжлийн холбоо, гишүүд, нягтлан бодогчид, сонирхогч бусад этгээд.</li></ul>	1	150
2		<ul style="list-style-type: none"><li>• Хүнс, хөдөө аж ахуйн салбарын татвар төлөгчид;</li><li>• Сонирхогч бусад этгээд.</li></ul>	1	140
3		<ul style="list-style-type: none"><li>• Барилга болон уул уурхайн салбарын татвар төлөгчид;</li><li>• Сонирхогч бусад этгээд.</li></ul>	1	140
4		<ul style="list-style-type: none"><li>• Аялал жуулчлал болон тээврийн салбар үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчид;</li><li>• Сонирхогч бусад этгээд.</li></ul>	1	130
5		Татварын албанд ажиллаж байсан албан хаагчид	1	14

6		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төв ТББ, иргэдийн төлөөлөл	1	11
7	Монгол Улсын Их Хурал	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	2	
8		Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль	1	
9		Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	1	
10	МҮХАҮТ	Хувийн хэвшил, хуульч, сэтгүүлч	1	200
11		Хувийн хэвшил, Том татвар төлөгчид	1	80
12		Хувийн хэвшил, салбарын төлөөлөл	1	80
13	Нийслэл, дүүргийн татварын газар	Татвар төлөгч иргэд	77	4,660
14	21 Аймгийн татварын газар	Татвар төлөгч иргэд	101	7,552

Үүнээс ирүүлсэн саналуудыг агуулгаар нь судлан үзэхэд нийт саналуудын 56 хувь нь татварын хувь хэмжээг өөрчлөхтэй, 27 хувь нь татварын хууль тогтоомжийн ойлгомжгүй байдлыг бууруулах, хэрэгжилтийг сайжруулахтай, үлдсэн 17 хувь нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой саналуудыг ирүүлсэн байв.

Улмаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу татварын хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлал, дагалдах тооцоо, судалгааны хамт 60 хоногийн хугацаанд Сангийн яамны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд олон нийтэд нээлттэй 60 хоногийн хугацаатай байршуулан санал авч дуусаад байна. Энэ хүрээнд олон нийтээс Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 237 саналыг ирүүлсэн байна.

Ийнхүү Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор 30,450 саналыг хүлээн авч, саналуудад дүн шинжилгээ хийж, судалсан. Тус саналуудыг агуулгаар нь судлан үзэхэд нийт саналуудын 48 хувь нь татварын хувь хэмжээ, 30 хувь нь хөнгөлөлт чөлөөлөлт, 12 хувь нь татварын босго, 6 хувь нь тайлагнал, 2 хувь нь хууль тогтоомжийн ойлгомжгүй байдалтай холбоотой саналуудыг ирүүлсэн байна.

Утга	Нийт	ХХОАТ	Санал тусгагдсан байдал		
			Авсан	Аваагүй	Сэтгэгдэл
Хувь хэмжээ	72,641	14,529	6,973	6,806	750
Хөнгөлөлт, чөлөөлөлт	20,182	9,284	3,972	5,078	234
Татварын суурь	34,683	3,701	1,218	2,375	108

Тайлагнал	5,663	1,699	919	129	651
Хууль тогтоомжийн ойлгомжгүй байдал	14,413	720	396	301	23
Татвар, гаалийн байгууллагын үйл ажиллагаа	19,459	-	-	-	-
Хариуцлага	2,959	-	-	-	-
Өр барагдуулалт	3,687	-	-	-	-
Бусад	2,759	517	278	220	19
<b>Нийт</b>	<b>176,416</b>	<b>30,450</b>	<b>13,756</b>	<b>14,909</b>	<b>1,785</b>

Хэлэлцүүлгийн үеэр татвар төлөгчдөөс ирүүлсэн саналыг нэг бүрчлэн судлан үзэж, нийт саналын 48 хувь буюу 13,756 саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан бол 14,909 саналыг хүлээн авах боломжгүй гэж үзлээ. Мөн үлдсэн 1,785 санал нь сэтгэгдэл, асуулт хэлбэртэй байлаа. Ирсэн саналын дийлэнх нь татварын хувийг бууруулах, татвар ногдуулах орлогын босго дүнг нэмэгдүүлэх, тайлагналын хугацаа, албан татвар ногдох орлогоос хасагдах зардал болон татварын хууль тогтоомжийн ойлгомжгүй байдалтай холбоотой байв.

Татварын шударга байх зарчмыг баримтлах, олон улсын татварын стандарт, зарчимд нийцээгүйн үүднээс иргэд, аж ахуйн нэгжээс хэлэлцүүлгийн явцад гаргасан татварын хувь хэмжээг бууруулах, зарим төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэмэгдүүлэх саналыг аваагүй болно.

#### **Татвар төлөгчдөөс ирүүлсэн саналуудыг тусгайлан авч үзвэл:**

<b>Ирүүлсэн санал</b>	<b>Тусгасан эсэх</b>	<b>Тайлбар</b>
Татварын хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний хэмжээтэй уялдуулж, нэмэгдүүлэх	доод Тусгасан	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасны дагуу жилийн 36 сая хүртэлх төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлоготой иргэдэд 240 мянга хүртэлх төгрөгийн шаталсан татварын хөнгөлөлт эдлүүлж, бага дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулдаг.  Хуулийн өөрчлөлтийн хүрээнд орлогын хэмжээ хамаарахгүйгээр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний буюу сарын 792 мянган төгрөг хүртэлх орлогод ногдох албан татварыг 100 хувь хөнгөлж, буцаан олгох зохицуулалтыг тусгасан.
Үйл ажиллагааны орлоготой иргэдийн хамрагддаг хялбаршуулсан горимыг дүнтэй болгох	босго Тусгасан	Жижиг дунд бизнес эрхлэгчдийн татвар тайлагнах, төлөх үйл ажиллагааг хялбаршуулан, татварын хамрагдалт, бүртгэлийг сайжруулах зорилгоор ХХОАТ-ын хялбаршуулсан горимд хамрагдах босго дүнг жилийн 1 тэрбум төгрөг болгосон.  Хуулийн төсөл батлагдсанаар жилийн 1 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой хувь хүмүүс хялбаршуулсан горимоор тайлагнаж, борлуулалтын

		орлогын 10 хувийг татвар ногдуулах орлого гэж үзэн 10 хувиар албан татвар төлөх боломжтой болно.
Бүх нийтээрээ шударга татвараа төлдөг болох	Тусгасан	Татварын шударга байх зарчимд үндэслэн үйл ажиллагааны орлогын хялбаршуулсан горимыг босготой болгон жилийн 1 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой иргэд тус горимд хамрагдах боломжийг бүрдүүлсэн.
Бүс орон нутагт ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх татварын эрх зүйн орчныг бүрдүүлэх	Тусгаагүй	Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суух иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэх, орон нутгийн эдийн засгийн бие даасан бодлого хэрэгжүүлэх нөхцөлийг хууль эрх зүйн хүрээнд бүрдүүлэх, боловсронгуй болгох зорилгын хүрээнд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд Улаанбаатар хотоос алслагдсан аймаг, хот, суманд 90 хүртэлх хувийн албан татварын хөнгөлөлтийг үзүүлж байна.
Татварын тайлагналыг хялбаршуулж, татвар төлөгчдөд уян хатан болгох	Тусгасан	Татвар төлөгчийг үүсэж болзошгүй татварын эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, татвар тайлагнах, төлөх үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор татварын тайлан тушаах болон төлөх өдрийг хойшлуулсан.
Оршин суугч бусын суутган татварын хувь хэмжээг бууруулах	Тусгаагүй	Олон улсын валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага зэрэг олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмж болон татвар төлөгчдийн саналд үндэслэн олон нийтээс санал авахаар байршуулсан хуулийн төсөлд тусгагдсан Монгол Улсад байрладаг аж ахуйн нэгжийн хувьцаа, хувь оролцооны 50 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчид олгосон тухайн хувьцааны ногдол ашгийн орлогод ногдуулах татварын хувь хэмжээг өөрчилсөн зохицуулалтыг төслөөс хассан.